



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/493

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 2.2.2.6, 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Арвайхээр сумын Онги-Өргөө сууц өмчлөгчдийн холбоонд нийтийн эзэмшлийн орон сууцнуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах зардалд 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Хужирт сум дахь Эрэн хайх аврах бүлгийн техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах грашийн түрээсийн зардалд 5,000,000 (таван сая) төгрөгийг зарцуулсугай.

3.Дээрх зардлыг үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011101085